



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО



ᠮᠤᠩᠭᠤᠯᠤᠯ ᠰᠤᠨᠬᠡᠭᠢ  
ᠰᠤᠨᠬᠡᠭᠢ ᠵᠣᠬᠢᠴᠤᠭᠤᠯᠠᠬᠤ  
ᠬᠣᠷᠤᠭ

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

## 2022 ОН

# АГУУЛГА

---

НЭГ.	МЭНДЧИЛГЭЭ	6
ХОЁР.	ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ	8
ГУРАВ.	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА	10
ДӨРӨВ.	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН	11
ТАВ.	ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	14
ЗУРГАА.	САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	15
ДОЛОО.	БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	16
НАЙМ.	БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	33
ЕС.	ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	35
АРАВ.	ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	38
АРВАН НЭГ.	МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	39
АРВАН ХОЁР.	ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА	41
АРВАН ГУРАВ.	СУДАЛГАА, ТОЙМ	43
АРВАН ДӨРӨВ.	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС	44
АРВАН ТАВ.	МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ	45
АРВАН ЗУРГАА.	ТӨСӨВ, САНХҮҮ	48
АРВАН ДОЛОО.	ОЛОЛТ, АМЖИЛТ	47

# ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

---

- |            |  |
|------------|--|
| Зураг 1.   | СЗХ–ны бүтэц, зохион байгуулалт  |
| Зураг 2.   | СЗХ–ны албан хаагчдын мэдээлэл   |
| Зураг 3.   | Санхүүгийн салбарын онцлох үзүүлэлтүүд   |
| Зураг 4.   | Санхүүгийн салбарын статистик үзүүлэлтүүд  |
| Зураг 5.   | Банк бус санхүүгийн байгууллагын салбарын тусгай зөвшөөрлийн мэдээлэл              |
| Зураг 6.   | Газар дээрх хяналт, шалгалтын мэдээлэл   |
| Зураг 7.   | Зайны хяналт, шалгалтын хүрээнд баталгаажуулсан тайлан, мэдээ /давхардсан тоогоор/ |
| Зураг 8.   | Улсын байцаагчийн албан шаардлагын мэдээлэл  |
| Зураг 9.   | Өргөдөл, гомдол, тэдгээрийн шийдвэрлэлтийн мэдээлэл                                |
| Зураг 10.  | Нийт зардал /хувиар/   |
|            |  |
| Хүснэгт 1. | Дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт  |
| Хүснэгт 2. | 2022 онд бүртгэгдсэн захиргааны хэм, хэмжээний актууд                              |
| Хүснэгт 3. | Зохицуулалтын салбарт зохион байгуулсан сургалтууд                                 |
| Хүснэгт 4. | Банк бус санхүүгийн байгууллагуудын зөвшөөрөл, бүртгэлийн мэдээлэл                 |

# ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

---

FTSE Russell

АНДМУТБ

АХБ

ББСБ

БЖДҮ

БНХАУ

БНЭУ

ВХ

ВХҮҮ

ГҮТББ

ДНБ

ЗЖДХ

ЗМС

МИК

МУТА

МУТС

МУТСТ

МУЭ

МХБ

НДЭШШ

НҮБ

ОУВС

Financial Times Stock Exchange Russell

Ази Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх байгууллага

Азийн хөгжлийн банк

Банк бус санхүүгийн байгууллага

Бичил, жижиг дунд үйлдвэрлэл

Бүгд Найрамдах Хятад Ард улс

Бүгд найрамдах Энэтхэг улс

Виртуал хөрөнгө

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч

Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага

Дотоодын нийт бүтээгдэхүүн

Зээлийн жигнэсэн дундаж хүү

Зээлийн мэдээллийн сан

Монголын ипотekiйн корпораци

Мөнгө угаахтай тэмцэх алба

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

Мэдээлэх үүрэгтэй этгээд

Монголын хөрөнгийн бирж

Нийслэлийн давж заалдах шатны шүүх

Нэгдсэн үндэсний байгууллага

Олон улсын валютын сан



# ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

---

СЭХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТТБ	Төрийн бус байгууллага
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБАШ	Улсын байцаагчийн албан шаардлага
УИХ	Улсын Их Хурал
ҮМҮЧЭТХЭАЭ	Үнэт металл, үнэт чулууны эдлэл, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч
ҮМҮЧЭТХЭХЭ	Үнэт металл, үнэт чулууны эдлэл, тэдгээрээр хийсэн эдлэлийн эрхлэгч
ҮХХЗБ	Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага
ҮХЭХЗ	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал
ҮЦЗЗ	Үнэт цаасны зах зээл
ҮЦК	Үнэт цаасны компани
ҮЦХОУБ	Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага
ФАТФ	Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага
ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ХЭДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ХК	Хувьцаат компани
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
ХНХБ	Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц
ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭБ	Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

## ■ МЭНДЧИЛГЭЭ



Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланг Танд өргөн барьж байна.

Цар тахлын дараах хөл хорио тавигдаж, иргэд олон нийт хэвийн амьдралдаа эргэн орж эдийн засаг сэргэж эхэлсэн, дэлхий нийтээр үнийн өндөр өсөлт, инфляцтай тэмцсэн, геополитикийн хурцадмал асуудлууд өрнөсөн амаргүй бас завгүй жилийг бид туулан өнгөрлөө.

Санхүүгийн зах зээл эдийн засгийн үйл ажиллагааны толь нь болдгийн жишгээр үнийн хэт халалтаас сэргийлэх чиглэлд баримталж буй улс орнуудын эдийн засгийн хумих бодлого, бодлогын өндөр хүүгийн нөлөөгөөр өнгөрсөн онд дэлхийн санхүүгийн зах зээл олон хүндрэлтэй тулгарсан хэдий ч 2022 он Монгол

Улсын санхүүгийн зах зээл болон Санхүүгийн зохицуулах хорооны хувьд өсөлт, шинэчлэлээр дүүрэн, бахархах амжилт арвинтай жил байлаа.

Тухайлбал Улсын Их Хурлаас 2021 онд баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд хийгдэж буй банкны реформ энэ онд амжилттай хэрэгжин системийн нөлөө бүхий оролцогчид болох Төрийн банк, Голомт банк хувьцаагаа олон нийтэд амжилттай санал болгон нийт 144.2 тэрбум төгрөгийг татан төвлөрүүллээ. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022–2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийн хүрээнд төрийн өмчит компаниудын хувьчлалын үйл ажиллагааг “Монголын хөрөнгийн бирж” эхлүүлэн анхдагч зах зээлийн арилжааны захиалга нь 485.6 хувийн биелэлттэй хаагдаж, Монголын хөрөнгийн зах зээлийн 30 гаруй жилийн түүхэн дэх шинэ амжилтыг бичилцлээ.

Мөн энэ онд манай улсын хөрөнгийн зах зээл биржийн болон биржийн бус гэсэн хос тулгууртай болж 1 их наядар үнэлэгдэх хөрөнгө оруулалт, арилжаа тус эрхзүй, санхүүгийн зах зээлд олон төрлийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдсэнээс гадна салбарын хууль, эрх зүй зохицуулалтын орчинд томоохон өөрчлөлт, шинэчлэл тохиосон жил боллоо. Даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр даатгагч баталгаа гаргах боломж үүссэнээр томоохон төсөл, орон сууцжуулах хөтөлбөрүүд болон жижиг, дунд бизнесийн үйл ажиллагаанд батлан даагч болох боломж бүрдлээ. Мөн Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль 20 жилийн дараа санхүүгийн зах зээл, технологийн хурдтай өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэгдэж батлагдахаар УИХ-аар хэлэлцүүлэгдэж байна.

## ■ МЭНДЧИЛГЭЭ

Түүнчлэн энэ онд Монгол улс ФАТФ-ын гишүүн бус орнуудаас зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулсан анхны улс болж улмаар ФАТФ-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн гишүүн орнуудад "сайн туршлага" хэмээн үнэлэгдэж өндөр хөгжилтэй улс орнуудад өөрсдийн туршлагаасаа хуваалцлаа. Мөн СЗХ нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулалтын орчныг бүрдүүлж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэж, Сэндбокс зохицуулалтын хүрээнд технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг амжилттай туршин нэвтрүүлж, Монгол Улсын санхүүгийн зах зээл, салбарын оролцогчдын үйл ажиллагааг дэлхийн жишиг, олон улсын хөгжлөөс хоцролгүйгээр бодлого, зохицуулалтын шийдлүүдээ гарган ажиллаж байна. Цаашид ч бид технологийн дэвшлийг ашиглан шинэ тутам хөгжиж буй санхүүгийн дэд салбаруудад хөгжингүй орнуудаас хоцролгүйгээр нэвтрэх боломжийг эрэлхийлэн ажиллах болно.

Энэхүү зохицуулалтын үр дүнд зохицуулалтын байгууллагын зах зээлийн үнэлгээ болон нийт хөрөнгө ДНБ-ний 23.2 хувьтай тэнцэх хэмжээнд хүрээд байна.


Ирэх онд биднийг цар тахлын дараах эдийн засгаа сэргээх, байгаль орчинд ээлтэй, илүү ухаалаг, илүү хүртээмжтэй тогтвортой өсөлтөд хүрэх нэн чухал зорилт хүлээж байна. Хоёр том гүрний дунд байрлах далайд гарцгүй, хүн ам цөөнтэй улсынхаа эдийн засгийг төрөлжүүлэн, хөгжүүлэх нэг гарц нь санхүүгийн салбарын оролцогчид бидний хамтын ажиллагаа билээ. Санхүүгийн зохицуулах хороо дунд хугацааны хөгжлийн бодлогын хүрээндээ олон тулгуурт, ухаалаг, хүртээмжтэй санхүүгийн зах зээлийг хөгжүүлэн, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад анхаарлаа хандуулан ажиллах болно.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ







#### Есдүгээр сар

Монгол Улсад анхны виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид бүртгэгдлээ.

«Iэrbум мод» аянд хоёр дахь жилдээ нэгдлээ.

Монгол Улсыг F I SE Russell группээс Хөгжиж буй зах зээл (Frontier Market) ангилалд албан ёсоор орсон талаар мэдээллээ.



#### Аравдугаар сар

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IO SCO)-ын 47 дахь жилийн тайлангийн хуралд оролцож, “Хяналт шалгалтын хамтын ажиллагааны олон талт санамж бичиг”-т нэгдлээ.

“Санхүүгийн зохицуулах хорооны стратеги, төлөвлөгөө (2022–2025)” батлагдав.



#### Арваннэгдүгээр сар

СЗХ-ны төлөөлөл олон улсын даатгалын зохицуулагчдын холбооны хуралд оролцлоо.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль батлагдаж, СЗХ-ны зохицуулалтын салбарын тоо нэмэгдэв.



#### Арванхоёрдугаар сар

Даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр даатгагч баталгаа гаргах боломж бүрдлээ.

Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагуудын нэгдсэн холбоотой санамж бичиг байгууллаа.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлаас 2005 онд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, 2006 онд Санхүүгийн зохицуулах хорооны дүрмийг тус тус баталж, СЗХ-ны бүрэн эрх, чиг үүрэг, үйл ажиллагааны хамрах хүрээг хуульчлан тогтоож өгснөөр СЗХ үйл ажиллагаагаа 2006 онд эхлүүлсэн.

СЗХ нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох

хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэй билээ.

7

Салбар

3716

Зохицуулалттай  
эггээд

2376

Даатгалын  
төлөөлөгч

### АЛСЫН ХАРАА

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн итгэлийг хүлээсэн ухаалаг санхүүгийн зах зээлийг цогцлооно.

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Олон тулгуурт, хүртээмжтэй, цахим технологид суурилсан санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.


### ҮНЭТ ЗҮЙЛС



## ■ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН


СЗХ нь СЗХ-ны 2020 оны 78 дугаар тогтоолоор байгууллагын бүтэц орон тоог баталснаар 2022 онд 9 газар, 5 хэлтэс, 5 алба, нийт 162 албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Зураг 1. СЗХ-ны бүтэц, зохион байгуулалт



2022 онд хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй зохицуулалтын байгууллагуудын нэгдсэн бүртгэл хөтөлж, шаардлагатай мэдээллүүдийг тогтоосон хугацаанд СЗХ-нд ирүүлэх, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, СЗХ-оос өгсөн чиглэлийн дагуу зохицуулалтын байгууллагуудад хяналт шалгалт хийх үүрэг бүхий орон нутгийн 62 төлөөлөгч 21 аймагт ажиллаж байна.

Зураг 2. СЗХ-ны албан хаагчдын мэдээлэл



## ХУРААНГУЙ

2022 онд улс орнууд Ковид-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулахад бодлогоо чиглүүлж, геополитикийн асуудал болон өндөр инфляцтай нүүр тулсан жил боллоо. Үүний улмаас дэлхийн хэмжээнд эдийн засгийн өсөлт 2.9 хувьд хүрэв. Монгол Улсын ДНБ 2022 онд 52.9 их наяд төгрөгт хүрч, 4.8 хувиар өслөө. Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр 17.2 их наяд төгрөг, нийт зарлага 18.1 их наяд төгрөг болж тэнцвэржүүлсэн тэнцэл 979.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, төсвийн алдагдал өмнөх оноос 1.9 (66.5%) их наяд төгрөгөөр буурчээ. Монгол Улс 2022 онд нийт 160 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 21.2 тэрбум америк доллар, үүнээс экспорт 12.5 тэрбум америк доллар, импорт 8.7 тэрбум америк доллар байна.

Үнэт цаасны зах зээлд 2022 онд 595 байгууллага зохицуулалттайгаар үйл ажиллагаа эрхэлж, данс эзэмшигчдийн тоо 2.4 саяд хүрлээ. Нийт үнэт цаасны арилжаа өнгөрсөн оноос 2.4 дахин буурч, 594.9 тэрбум төгрөгт хүрэв. Харин зах зээлийн үнэлгээ 6.9 их наяд төгрөгт хүрч 15.2 хувиар өссөн бол ТОП-20 индекс 6,846.1 нэгжээр буурч 37,565.55-д хүрсэн байна.

ХАА-н гаралтай бараа, таваарын зах зээлийн хувьд тайлант онд 8 төрлийн 1,110.0 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оноос 39.8 хувиар өсжээ.

Даатгалын салбарт нийт 323 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, актуарч, 2,376 даатгалын төлөөлөгч бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэн ажиллажээ. Даатгалын салбарын нийт хөрөнгө 474.9 тэрбум төгрөгт хүрснээс 45.7 хувь буюу 216.9 тэрбум төгрөгийг нөөц сан эзэлж байна. Ердийн болон урт хугацааны даатгалын салбар тайлант онд 483.4 их наяд төгрөгийн даатгалын үнэлгээтэй 3.9 сая зүйлийг даатгаснаар нийт хураамж өмнөх оноос 23.6 хувиар өсөж 300.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлжээ. Үүнээс давхар даатгалын хураамжид 100.0 тэрбум төгрөг төлсөн нь өмнөх оноос 18.5 хувиар өссөн. Даатгалын хохирлын нөхөн төлбөрийн зардал өмнөх оноос 36.7 хувиар өсөж 94.2 тэрбум төгрөгийг нөхөн төлбөрт олгосон нь нийт хураамжийн 31.3 хувийг эзэлж байна.

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт тайлант онд 513 ББСБ үйл ажиллагаа явуулж, салбарын

харилцагчдын тоо өмнөх оноос 3.9 хувиар буурч 4.6 саяд хүрсний 94.2 хувь нь финтекийн харилцагчид байна. Зээлдэгчдийн тоо 29.2 хувиар буурч 1.7 саяд хүрснээс финтекийн зээлдэгчид 78.8 хувийг эзэлж байна. Нийт хөрөнгө 3.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 30.2 хувиар өсөв. Үүний 2.7 их наяд төгрөгийг зээлийн өрийн үлдэгдэл эзэлж байгаа бөгөөд нийт зээлийн үлдэгдлийн 88.2 хувийг иргэдийн зээл, 11.8 хувийг хуулийн этгээдийн зээл бүрдүүлж байна.

Хадгаламж, зээлийн хоршоодын тоо өмнөх оноос 13-аар буурч 196 болж, гишүүдийн тоо 5 хувиар буурч 71,657-д хүрлээ. Тайлант онд ХЗХ-дын нийт хөрөнгө өмнөх оноос 8.1 хувиар буурч 267.7 тэрбум төгрөгт хүрчээ.

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын 305 компани тусгай зөвшөөрөлтэйгөөр тайлант онд үйл ажиллагаа эрхэлсэн ба нийт 8,983 хэлцлээр 1,971.5 мянган м.кв талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгийг 1,705.3 тэрбум төгрөгөөр худалдах, худалдан авах үйл ажиллагааг зуучилсан. Харин 7,700 хэлцлээр 465.9 мянган м.кв талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгийг 102.1 тэрбум төгрөгөөр хөлслүүлж, түрээслүүлэх үйл ажиллагааг тус тус зуучилсан байна.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааны 47 хуулийн этгээд, 465 иргэн тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж, 670.8 тэрбум төгрөгийн үнэт металлыг худалдаж, 700.1 тэрбум төгрөгийн үнэт металлыг худалдан авчээ.

8 Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160

☎ 976-51-264444

✉ [press@frc.mn](mailto:press@frc.mn)

🌐 [www.frc.mn](http://www.frc.mn)

📍 Санхүүгийн зохицуулах хороо

📱 @FRC\_of\_Mongolia





## ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зураг 3. Санхүүгийн салбарын онцлох үзүүлэлтүүд



## ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

ОУВС-ын тооцоолсноор 2022 онд дэлхийн эдийн засаг 2.7 хувиар өсөж 2001 оноос хойшх хамгийн бага өсөлт тохиолдов.

Үүнээс хөгжсөн зах зээлтэй орнуудын эдийн засаг 2.7 хувиар, хөгжиж буй зах зээлтэй орнуудын эдийн засаг 3.9 хувиар тус тус өссөн байна.

Өндөр инфляцын улмаас төв банкууд 1994 оноос хойш анх удаа бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн жил болов.

Геополитикийн асуудал, Ковид-19 цар тахлын нөлөөллийн үргэлжлэл инфляц өсөх, санхүүгийн ноцол байдал хүндрэхэд нөлөөлсөн.

Ковид-19-ийн нөлөөгөөр БНХАУ-ын эдийн засаг удааширнаар олон улсын худалдаа болон бараа, таваарын үнэ буурсан.

Хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүд 2022 онд өмнөх оноос дараах байдлаар өөрчлөгдлөө.


- MSCI индекс 24.1 хувиар;
- S&P 500 19.4 хувиар;
- NASDAQ 33.1 хувиар;
- Германы DAX 21.5 хувиар;
- Японы Nikkei 10.7 хувиар;
- Францын CAC 13.4 хувиар ;
- БНХАУ-ын CSI 300 1.2 тус тус буурсан.

Сүүлийн 2 жилд газрын тосны үнэ 50 хувь, байгалийн хийн үнэ 48 хувь, зэсийн үнэ 25 хувиар тус тус өслөө.

Хүнсний бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн оноос 28.1 хувиар өсөж, үнийн дундаж индекс 133.7 нэгж болсон нь 2020 оноос 23.1 хувиар өссөн байна.

## ■ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Зураг 4. Санхүүгийн салбарын статистик үзүүлэлтүүд



### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

- » ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТОО: 318
- » ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИЙН ТОО: 52
- » ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ДҮН: 594.9 тэрбум төгрөг
- » ХАА-н гаралтай барааны арилжааны дүн: 1.1 их наяд төгрөг
- » МИК: 67,103 зээлдэгчид 3.4 их наяд төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

### ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

- » НИЙТ ХӨРӨНГӨ: 474.9 тэрбум төгрөг
- » НИЙТ ХУРААМЖ: 300.7 тэрбум төгрөг
- » НӨХӨН ТӨЛБӨР: 94.2 тэрбум төгрөг
- » НӨӨЦ САН: 216.9 тэрбум төгрөг
- » ГҮНЗГИЙРЭЛТ: 0.63 хувь
- » НЯГТРАЛ: 87,816 төгрөг

### БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР


- » ББСБ-ЫН ТОО: 513
- » НИЙТ ХӨРӨНГӨ: 3.5 их наяд төгрөг
- » НИЙТ ЗЭЭЛ: 2.7 их наяд төгрөг
- » ЗЖДХ: 3.1 хувь
- » ЗЭЭЛДЭГЧДИЙН ТОО: 1.7 сая
- » ЧАНАРГУЙ ЗЭЭЛИЙН НИЙТ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ: 7.6 хувь

### ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САЛБАР

- » ХЗХ-НЫ ТОО: 196
- » НИЙТ ХӨРӨНГӨ: 267.7 тэрбум төгрөг
- » НИЙТ ЗЭЭЛ: 210.2 тэрбум төгрөг
- » НИЙТ ХАДГАЛАМЖ: 187.5 тэрбум төгрөг
- » ЗЖДХ: 2.3 хувь, ХЖДХ: 1.2 хувь
- » ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН ТОО: 38.5 мянга
- » ЗЭЭЛДЭГЧДИЙН ТОО: 32.4 мянга



## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Түүнчлэн компанийн засаглал болон СЗХ-ны дотоод үйл ажиллагаатай холбоотой тус бүр нэг тогтоол гарсан байна. СЗХ-ны тогтоолыг цахим хуудас, [Lisence.frc.mn](http://lisence.frc.mn) хуудсанд тухай бүр оруулж, олон нийтэд мэдээлэл хүргэн ажиллалаа.





## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Зохицуулалтын орчин:** Санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой 27 хууль, 119 дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангуулж ажилласан. Нийт дүрэм, журам, зааврын 55 нь үнэт цаасны зах зээлд, 25 нь даатгалын салбарт, 16 нь ББСБ-ын салбарт, 6 нь ХЗХ-ны салбарт, 6 нь ҮХХЗҮЭЗ-ын салбарт, ВХҮҮ-ийн салбарт 8, бусад 3 дүрэм, журам, зааврыг зохицуулалтын хүрээндээ хэрэгжүүллээ.

**Бодлогын хэрэгжилт:** Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 бүлэг 47 зорилтын хүрээнд 257 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилийн байдлаар тайлагнасан байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, төлөвлөсөн түвшинд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн дүнгээр 95 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй байна.

Хүснэгт 1. Дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт

№	Дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Гүйцэтгэл
1	Алсын хараа– 2050	41	96%
2	МУ-ыг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	10	99%
3	Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл	8	–
4	Монгол Улсын Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	12	98%
5	Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл	6	–
6	Зээлийн хүүг бууруулах стратегийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө	14	97.2%
7	Шинэ сэргэлтийн бодлого	4	92%
8	Мөнгөний болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх төлөвлөгөө	10	94.3%
9	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоол /Коронавируст халдвар /ковид–19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээ/	6	100.0%
10	Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр	69	83.8%
11	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр	21	100%
НИЙТ		201	–

Санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой УИХ-аас баталсан 9, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2 бодлогын баримт бичгийн 201 заалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг гүйцэтгэлээ.



## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх хүрээнд

СЗХ-оос 2022 онд баталсан нийт 12 захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн тухай бүр захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлж ажилласан.

Хүснэгт 2. 2021 онд бүртгэгдсэн захиргааны хэм, хэмжээний актууд

№	Тогтоол, тушаалын нэр, дугаар	ХЗДХЯ-нд бүртгэгдсэн өгнөө	Захиргааны хэм хэмжээний актын нэр
1	СЗХ-ны 2022 оны 145 дугаар тогтоол	5783	Компанийн засаглалын кодекс
2	СЗХ-ны 2022 оны 160 дугаар тогтоол	5807	Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам
3	СЗХ-ны 2022 оны 174 дугаар тогтоол	5809	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам
4	СЗХ-ны 2022 оны 175 дугаар тогтоол	5810	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам
5	СЗХ-ны 2022 оны 176 дугаар тогтоол	5811	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох журам
6	СЗХ-ны 2022 оны 177 дугаар тогтоол	5812	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоонд тавих шаардлагыг тогтоох журам
7	СЗХ-ны 2022 оны 305 дугаар тогтоол	5847	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам
8	СЗХ-ны 2022 оны 306 дугаар тогтоол	5848	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хязгаарлах, түр зогсоох, бүртгэлээс хасах журам
9	СЗХ-ны 2022 оны 275 дугаар тогтоол	5850	Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам
10	СЗХ-ны 2022 оны 276 дугаар тогтоол	5851	Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам
11	СЗХ-ны 2022 оны 360 дугаар тогтоол	5886	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам
12	СЗХ-ны 2022 оны 520 дугаар тогтоол	5980	Төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцааг эзэмшихтэй холбоотой хуульд заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавих журам



## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

#### ХБҮЦ–ны хоёрдогч зах зээлийг хөгжүүлэв

2011 онд батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ыг дотоодын хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал, олон улсын санхүүгийн зах зээлд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зохицуулалтад гарч буй өөрчлөлт зэргээс үүдэж хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгох, арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлэх, анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зохицуулалтыг бий болгож, ХБҮЦ–ны хоёрдогч зах зээлийг эрчимжүүлэх шаардлага тулгарсан. Энэ хүрээнд “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ыг өөрийн орны онцлог, зах зээлийн нөхцөл байдал болон олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн батлав.



#### Банкны салбарын реформ амжилттай хэрэгжив

Улсын Их Хурлаас 2021.01.29–ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталснаар банкны системд нөлөө бүхий банкнууд 2023.06.30–ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани болох, мөн нэг хувьцаа эзэмшигчийн хувьцааны төвлөрлийг 20 хувиас хэтрүүлэхгүй байх шаардлагыг 2023.12.31–ний өдрийн дотор хэрэгжүүлэх үүрэг хүлээснээс системийн нөлөө бүхий 2 банк олон нийтэд хувьцаагаа амжилттай арилжиж зах зээлийн үнэлгээг 1.5 их наяд төгрөгөөр нэмэгдүүлээд байна.

#### Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын бааз суурийг бэхжүүлэх бодлогын хүрээнд

СЗХ–оос олон улсын санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг дотоодын зах зээлд нэмэгдүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаа, оролцоог дэмжсэн “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”, “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”–уудыг 2022.05.25–ны өдөр тус тус шинэчлэн баталсан.

Эдгээр журмууд батлагдсанаар хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулахад тавигдах нөхцөл, шаардлага илүү хялбар болсноос гадна хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, нэгж эрхийн танилцуулгыг олон нийтэд танилцуулах, сангийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааны зохион байгуулалт, сангийн үйл ажиллагаа, активт тавих шаардлага, мэдээллийн ил тод байдалтай холбоотой зохицуулалт сайжрах боломж бүрдсэн.

Түүнчлэн олон улсын санхүүгийн зах зээлд өргөн хүрээнд ашиглагддаг хамтын сангийн төрөл болох биржээр арилжаалагддаг сан /ETF/–ийн зохицуулалтыг бий болгож, сангийн нэгж эрхийг анхдагч, хоёрдогч зах зээлд санхүүгийн хэрэгслээр солилцох ажиллагааг зохион байгуулах, уг үйл ажиллагаанд оролцогч мэргэжлийн үнэт цаасны компани /authorised participants/–д тавих нөхцөл, шаардлагыг тусгасан.





## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Төрийн өмчийн компаниудын хувьчлал

Улсын Их Хурлын 2022.04.29-ний өдрийн 16 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022–2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг баталсан. Үүнтэй холбогдуулан Засгийн газраас 2022.06.29-ний өдрийн хуралдаанаар 2022–2023 онд биржээр төрийн мэдлийн 34 хувийн хувьцааг нээлттэй худалдах, олон нийтийн хяналтад шилжүүлэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг баталсан. Энэ хүрээнд төрийн өмчит компаниудын хувьчлалын үйл ажиллагааг “Монголын хөрөнгийн бирж” эхлүүлж хувьцааныхаа 34 хувийг олон нийтэд санал болгож нээлттэй хувьцаат компани болоод байна.



### Мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг дэмжих хүрээнд

Эдийн засгийн нэг салбарыг дагнасан мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хамтын хөрөнгө оруулалтын сангуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, банкны салбарын реформын хүрээнд системийн банкнуудад хөрөнгө оруулалт хийх бололцоог өсгөх хэрэгцээ, шаардлагын улмаас “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан.

### Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөлийн хүрээнд

Хөрөнгийн зах зээлийн татварын эрх зүйн орчинд гарч буй зэрэг өөрчлөлт, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны шимтгэл, хураамжийн хэмжээ буурч байгаа нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдын бааз суурийг бэхжүүлэхээс гадна гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, цаашлаад хөрөнгийн зах зээлийн санхүүгийн салбарт эзлэх байр суурийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж дүгнэсэн.

Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ болон УИХ-аас баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хүрээнд хөрөнгийн зах зээлийн татварын орчин, шимтгэл хураамж, зах зээлийн мэргэжлийн байгууллагууд, хөрөнгө оруулагчдад ногдох татварын таатай орчныг бүрдүүлэх, татварын уян хатан бодлогоор Монгол Улсын томоохон ААН-үүдийг урамшуулалтайгаар биржид нээлттэй хувьцаат компани болгон бүртгүүлэх боломжийг нээх зорилгоор “Хөрөнгийн зах зээлд гарч буй бодлого, зохицуулалтын үр нөлөө болон татварын эрх зүйн орчин” сэдэвт хэлэлцүүлгийг 2022.12.06-ны өдөр зохион байгуулсан.

### Дэд бүтцийн хөгжлийн хүрээнд

Хөрөнгийн зах зээлд үнэт цаасны дараа төлбөр тооцооны горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг 2020 онд амжилттай нэвтрүүлснээр манай улсын үнэт цаасны төлбөр тооцооны горим олон улсын жишигт нийцэж, 2021.09.30-ны өдөр FTSE Russell-с Монгол Улсыг Хөгжиж буй зах зээл (Frontier market) ангиллын “Ажиглалтын жагсаалт”-д буцаж орсон талаар албан ёсоор мэдэгдсэн бол 2022.09.29-ний өдөр FTSE Russell группээс Хөгжиж буй зах зээл (Frontier Market) ангилалд албан ёсоор орлоо.



## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Арилжааны хэлцлийн зардлыг бууруулах, арилжаа хийгдэх шат дамжлагыг багасгах ажлын хүрээнд:

- Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1 хувь байсныг нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн хэмжээнээс хамааруулан хязгаар тогтоосноор 50–75 хувиар бууруулан 0.25–0.5 хувь болсон. Мөн жилийн үйлчилгээний хөлсний хэмжээ сангийн цэвэр хөрөнгийн дүнгийн 0.1 хувь байсныг 50 хувиар бууруулж 0.05 хувь боллоо.
- Хувьцаа бүртгэх үйлчилгээний хөлс нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 0.1 хувь байсныг үнийн дүнгээс хамааруулан 20–40 хувиар бууруулан 0.06–0.08 хувь болгов. Мөн орийн хэрэгсэл бүртгэх үйлчилгээний хөлс үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлбэл зохих мөнгөн хөрөнгийн 0.1 хувь байсныг үнийн дүнгээс хамааран 0.064–0.1 хувь болж буурсан.
- “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Арилжааны журам”-д хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжаанд худалдсан тал шимтгэл төлөхгүй, түүнчлэн худалдан авсан талын хувьд хэлцлүүдийн үнийн нийлбэр дүнгээс хамааруулан шимтгэлийг тооцдог байхаар зохицуулалтыг тусгасан.



## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ



#### Даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга

Даатгалын багц хууль буюу Даатгалын тухай, Даатгалын зуучлалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан 2022.05.18-ны өдөр Сангийн яам болон СЗХ-ны цахим хуудсанд байршуулж, Хууль тогтоомжийн хуулийн дагуу иргэд олон нийт, мэргэжлийн холбоодоос санал авсан. Сангийн яам, мэргэжлийн холбоод, даатгалын компаниуд, мэргэжлийн оролцогчдыг хамруулсан нэгдсэн хэлэлцүүлгийг 2022 оны 11 дүгээр сард зохион байгуулж ирүүлсэн санал болон тулгамдаж буй асуудлуудын талаар санал солилцож Даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэсэн.



#### Ногоон даатгалын зохицуулалт

Ногоон даатгалын бүтээгдэхүүний эрх зүйн орчныг бий болгох зорилгоор СЗХ-ны 2022 оны 129 дүгээр тогтоолоор Даатгалын багц дүрмийн 1, 2, 4, 11 дүгээр хавсралтуудад холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн дагуу ногоон даатгалын бүтээгдэхүүнийг Монгол Улсын Ногоон таксономитай уялдуулж, даатгалын гэрээний нөхцөл шаардлагыг тодорхой болгохын зэрэгцээ даатгагчийн ногоон бондод хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлэх чиглэлээр зохицуулалтуудыг тусгасан. Мөн даатгагчаас ногоон даатгалын бүтээгдэхүүний чиглэлээр тайлан, мэдээ хүлээн авах загварыг бий болгосноор дээрх чиглэлээр нэгдсэн мэдээллийн сан үүсэх нөхцөл бүрдсэн.

#### Эрсдэлд суурилсан хөрөнгө тооцох аргачлал

Даатгалын компаниудын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах, оновчтой хэлбэрээр хэрэгжүүлэх, эрсдэлийн үнэлгээний аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэх, даатгагчийн эрсдэлийг илүү бодитой, нарийвчилсан, өөрт тохирсон аргаар тооцоолох боломжийг олгох, хөрөнгө оруулалтын эрсдэлийг тодорхойлж, түүний боломжийг нэмэгдүүлж эрсдэлийг тархах зорилгоор “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”, “Даатгагчийн эрсдэлд суурилсан хөрөнгө тооцох аргачлал”-ыг СЗХ-ны 2022 оны 558 дугаар тогтоолоор баталсан.





## ■ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд баталгааны даатгалын чиглэлээр холбогдох зохицуулалтыг тусган хамтран ажилласан. Даатгагчийн баталгаа нь зээлжих чадвар хангалтгүй гүйцэтгэгч нарт зээлийн дэмжлэг үзүүлдэг даатгалын компанийн эрхэлдэг даатгалын үйл ажиллагааны нэг хэлбэр бөгөөд жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд ихээхэн дэмжлэг үзүүлдэг онцлогтой юм.



Даатгалын бодлогын зөвлөл 2022.05.25-ны өдөр хуралдаж, Даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, иргэд олон нийтийн даатгалын боловсролыг дээшлүүлэх, даатгалын салбарын татварын асуудлаар тус тус санал солилцож ажилласан.


Зөвлөлийн хурлаас Даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дэмжин, хууль тогтоомжид заасны дагуу холбогдох процессыг хэрэгжүүлэх зөвлөмж гаргасан. Мөн цаашид бодлогын зөвлөлийн хурлыг тогтмолжуулж салбарын хэмжээнд тулгараад байгаа асуудлуудыг хэлэлцэх тал дээр санал нэгдсэн.





## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР:



#### Хууль, эрхзүйн орчны шинэчлэлийн хүрээнд

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2022.04.20-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Монгол Улсын Их Хурлын 2022.05.19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхийг дэмжиж Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль нь 2002 онд батлагдсанаас хойш 9 удаа нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд энэхүү нэмэлт өөрчлөлт нь бусад хуулийг дагаж гарсан байдаг. Хууль батлагдсанаас хойших 20 жилийн хугацаанд салбарын оролцогчдын үйл ажиллагаа өргөжиж хөрөнгийн зах зээлд гарах, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх замаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхтэй зэрэгцэн хууль эрх зүйн орчныг зайлшгүй сайжруулах нөхцөл үүссэн.

Санхүү, төлбөрийн чадвар, хөрөнгийн өгөөж, үйл ажиллагааны онцлог, үйлчилгээний эрсдэлийг бууруулах зорилгоор ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүллээ. 2022 онд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай 232 ББСБ-аас 90 хувь буюу 209 ББСБ-ууд 65 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.



Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль Монгол Улсын Их Хурлын 2022.11.04-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар батлагдаж, барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгч СЗХ-нд бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа явуулахаар зохицуулагдсан. Тус хуулиар санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалагдах, зээлийн хүүгийн өндөр дарамтад орохоос урьдчилан сэргийлэх, зээлийн хүүгийн хязгаарлалт тогтоох зэрэг харилцаанууд зохицуулагдсан. Энэхүү хууль батлагдсанаар барьцаалан зээлдүүлэх газар, ашиг олгох зорилгоор зээл олгож буй иргэн хүртэл хуулийн хүрээнд СЗХ-нд бүртгүүлнэ.

ББСБ-ын салбарын шимтгэл, хураамжийг үндэслэлтэй тогтоох, зээлийн хүүг ашигласан хугацаагаар тооцох, зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг ил тод мэдээлэх, зээлдэгчээс гэрээнд тусгаагүй хүү шимтгэл авахгүй байх, зээлдэгчид хууль бус дарамт шахалт үзүүлэхгүй байх зэрэг зээлдэгчийн эрх ашгийг хамгаалсан “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан.



## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Тогтвортой, ногоон санхүүжилтийн хүрээнд

Салбарын хэмжээнд анх удаа Монголын ногоон таксономийн 8 ангиллын хүрээнд ногоон зээлийн бүтээгдэхүүн болон санхүүгийн хүртээмжийн үзүүлэлт болох жендерийн үзүүлэлтийн мэдээллийн санг бүрдүүлээ.



### Технологийн дэвшлийн хүрээнд

ББСБ-аас олгох финтек зээлийн бүтээгдэхүүнд өр, орлогын харьцааг 70 хувиас хэтрүүлэхгүй байхаар хязгаарлалаа. СЗХ-оос харилцагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор анх удаа өр, орлогын харьцааг финтек зээлийн бүтээгдэхүүнд тогтоосон онцлох үйл явдал боллоо.



Тогтвортой санхүүжилтийг нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор ББСБ-уудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн зааврыг баталсан.



СЗХ-оос технологийн MNS207001:2021 стандартыг нэвтрүүлсэн, харилцагчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангасан технологид суурилсан зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Журмын шаардлагаар MNS207001:2021 стандартыг хангасан, мэдээллийн аюулгүй байдал болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх нөхцөл шаардлагыг тавьж өгсөн. Ингэснээр харилцагчийн мэдээллийн аюулгүй байдал хангасан бодлогын чухал арга хэмжээ болсон.

## ■ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САЛБАР:

Азийн Хөгжлийн Банкны “Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө Зүүн Азийн жендерийн тэгш байдлыг эрчимжүүлэх” бүсийн техникийн туслалцааны төсөлд санал боловсруулж хүргүүлсний дагуу төслийн дэд хэсэг болох “Жендерийн мэдрэмж бүхий ногоон санхүүжилт төсөл”-ийг 2022–2024 онд ХЗХ-ны зах зээлд хэрэгжүүлэхээр 2022 оны 9 дүгээр сараас төслийн үндэсний зөвлөх ажиллаж эхэлсэн. Тус төслийн бэлтгэл ажил болгож ХЗХ-ны гишүүн өрхийн үйлдвэрлэл эрхлэгч, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн судалгааг хийсэн бөгөөд судалгаанд хамрагдсан 144 хоршооны нийт гишүүдийн 18.0 хувь буюу 9,151 гишүүн өрхийн үйлдвэрлэл, БЖДҮ эрхлэгчид байна.



ХЗХ-ны зах зээлд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журам”-ын төслийг боловсруулсан бөгөөд аргачлалын маягтыг Фина системд үүсгэн туршиж байна.

СЗХ, Зээлийн батлан даалтын сан, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооны хамтарсан ХЗХ-дыг зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд хамруулах, хоршооны гишүүн бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд олгох зээлийг батлан даах боломжийг судлах, боломжит шийдлийг тодорхойлох чиг үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж, 10 ХЗХ-г туршихаар үнэлгээ хийсэн.





## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАР:

- Зөвшөөрлийн тухай хууль 2023.01.01-ний өдрөөс эхлэн хэрэгжихтэй холбогдуулан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулав.
- Барилга хот, байгуулалтын яамны “Орон сууцны бүртгэл, мэдээллийн нэгдсэн портал”-ыг үйл

ажиллагаанд туршиж эхэлсэн бөгөөд системийн хөгжүүлэлтэд санал өгч, хамтран ажиллаж байна.

- Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагын эрх бүхий албан тушаалтан, хаяг байршил, агентын өөрчлөлтийн бүртгэлийг цахимжуулах ажлыг зохион байгуулж, QR код бүхий 95 цахим албан тоотыг үйл ажиллагаанд ашиглаж эхлэв.



### ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН САЛБАР:

- Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн эрх олгох сургалтын цахим системийг хөгжүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлээд байна.
- “Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн үндэсний холбоо” ГҮТББ-тай хамтран “MONGOLIAN JEWELLERY & METAL EXPO-2022” үзэсгэлэн болон салбарын оролцогчдын нэгдсэн уулзалт, форумыг 2022.04.15–17-ны өдрүүдэд “Мишээл экспо” олон улсын худалдааны танхимд зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээний хүрээнд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн зах зээлийг хөгжүүлэх зөвлөмжийг боловсруулж, холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлэн санал солилцсон.
- “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын шинэчилсэн найруулгын төсөлд санал өгч хамтран ажилласан. Үүний үр дүнд Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор тус журмыг баталж, улмаар үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн

арилжаа эрхлэгчдийг нэгдсэн бодлогоор хангах ажлын эхлэл тавигдсан.

- The Planet Gold төслийн Монгол Улс дахь суурин төлөөлөгчид болон холбогдох бусад төрийн байгууллагуудтай хамтран Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудад 2022.10.13–14-ний өдрүүдэд “Алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээтэй танилцах үзлэг, хэлэлцүүлгийг”-ийг зохион байгуулав.
- Монгол Улсын ерөнхийлөгчийн ивээл дор 2022.07.01-ний өдөр зохион байгуулагдсан “МОНГОЛ УРАН ДАРХАН 2022” үзэсгэлэн арга хэмжээнд уран дархчуудын үйл ажиллагааны зохицуулалтын талаарх мэдээллийг иргэдэд хүргэн ажиллалаа.



## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДИЙН САЛБАР

#### Хууль, эрхзүйн орчныг бүрдүүлэх хүрээнд

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 20.9.2-д заасны дагуу СЗХ нь 10 орчим харилцааг зохицуулсан нэр бүхий 8 журмыг ФАТФ-ын стандарт, олон улсын шилдэг туршлагад үндэслэн боловсруулан батлуулсан.

#### Хяналт, шалгалтын хүрээнд

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын онцлогт тохируулан блокчэйн гүйлгээний хяналтын "Chainalysis" программыг ашиглахаар бэлтгэл ажил хангагдаад байна. Дээрх гүйлгээний хяналтын программ нь НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн хориг арга хэмжээний жагсаалт, улс орнуудын хориг арга хэмжээний жагсаалтад заасан хэтэвчний мэдээллүүдийг хадгалдаг тул мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад төрлийг хэвийн бус гүйлгээг автоматаар хянах боломжтой юм.

Түүнчлэн, тус салбарын гүйлгээний тоон мэдээллийг өдөр бүрийн 7 цагт "API" холболтоор хянах хяналтын программыг дотоод нөөц бололцоогоор хөгжүүлж, туршилтын хугацаа үргэлжилж байна.

Азийн хөгжлийн банк Монгол улсад E-KYC болон цахим гарын үсгийн туршлагыг бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилготой төсөл хэрэгжиж эхэлсэн бөгөөд банкны салбарын тогтвортой байдлыг хангах үр ашгийг сайжруулах төслийн 3-р гарц үйл ажиллагааг СЗХ хариуцан хэрэгжүүлэхээр тохиролцож техник туслалцаа эхлээд байна. Уг туслалцааны хүрээнд дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг хянахад туслах;
2. Монгол Улсад "E-KYC" болон цахим гарын үсгийн практикийг бий болгоход дэмжлэг үзүүлэх;
3. Регтек /зохицуулалтын технологи/ болон Сунтек /хяналт шалгалтын технологи/-ийг Монголд ашиглах;
4. Дижитал банк болон финтек үйлчилгээг дотоодын зах зээлд амжилттайгаар хэрэгжүүлсэн туршлагыг хуваалцах.



Монгол Улс анх 2021 оны 01 дүгээр сард виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэсэн. Гэвч 2021 оны сүүлийн хагас жилд манай улсын виртуал хөрөнгийн салбар идэвхижиж, үйлчилгээ үзүүлэгчийн тоо нэмэгдсэн тул эрсдэлийн үнэлгээг шинэчлэх шаардлага үүссэн. Иймд, Дэлхийн банкнаас боловсруулсан аргачлалын дагуу үндэсний хэмжээнд виртуал хөрөнгийн салбарын эрсдэлийг үнэлэх ажлын хэсгийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс байгуулж, тус ажлын хэсгийг СЗХ-оос ахалж ажилласан.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хууль, эрх зүйн орныг боловсронгуй болгохтой холбогдуулан нийт 11 хэлэлцүүлгийг 290 оролцогчтойгоор зохион байгуулав.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын үндэсний эрсдэлийн үнэлгээг боловсруулах ажлын хүрээнд төр, хувийн хэвшлийн төлөөллүүдийг хамруулсан уулзалт, хэлэлцүүлгийг тухай бүр зохион байгуулав.

Монгол Улсад дагаж мөрдөж буй Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль болон холбогдох харилцааг зохицуулсан журмуудыг эмхэтгэн гарын авлага хэвлүүлж, тараав.

2022 оны байдлаар СЗХ-ны цахим хуудсанд МУТС гэмт хэрэг, цаг үеийн мэдээ, анхаарах асуудлуудын хүрээнд 23 удаагийн хэвлэлийн мэдээг байршуулж ажиллав.





## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Сэндбокс зохицуулалтын орчин

Сэндбоксын орчинд ирүүлсэн хүсэлт, бүтээгдэхүүн үйлчилгээний төрлөөр:



### Сэндбоксад туршигдаж буй бүтээгдэхүүнүүд

2022 оны 4 дүгээр улиралд дараах нэр бүхий 3 бүтээгдэхүүн, үйлчилгээг сэндбокс зохицуулалтын орчинд 1 жилийн хугацаатайгаар нэмж оруулан, 1 бүтээгдэхүүнийг гаргаж нийт 4 бүтээгдэхүүн, үйлчилгээ туршиж байна.



Монимаркет вэб системээр дамжуулан репо хэлцлийн хүсэлт хүлээн авах, хэлцлийн дагуу худалдах, худалдан авах үйлчилгээ. Тус платформоор 2022 онд нийт 439 удаагийн хэлцлээр 64.06 тэрбум төгрөгийн репо арилжаа хийгдсэн байна.



Зээл.мн Р2Р үйлчилгээ нь Монгол Улсын санхүүгийн зах зээлд шинээр нэвтэрч буй үйлчилгээ бөгөөд хиймэл оюун ухаан, блокчэйн технологийг ашиглан зээлийн онооны үнэлгээ, бүртгэл хийн хөрөнгө оруулагч, зээлдэгч хоёрыг шууд холбодог давуу талтай.



Лайка үйлчилгээ нь технологид суурилсан даатгалын үйлчилгээ бөгөөд хэрэглэгч өөрийн хэрэгцээ шаардлага, эрсдэлд нийцсэн даатгалын бүтээгдэхүүнийг ямар нэгэн зуучлагчгүйгээр өөрөө сонгон хэрэглэх, мөн эрсдэлд суурилсан газрын зураглалыг хөгжүүлж, даатгалын эрсдэлийг үнэлэх зэрэг олон төрлийн давуу талыг хэрэглэгчдэд санал болгож буй.



Финбэрри үйлчилгээ нь зээл, урамшуулал, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээ бөгөөд жижиг, дунд, бизнес эрхлэгчид, аж ахуй нэгжүүдэд төслийн санхүүжилтийн хэрэгцээгээ түргэн шуурхай шийдэх боломжийг санал болгож байна.

### Сэндбоксоос гарсан бүтээгдэхүүн, үйлчилгээ:



Монпэй дигитал бонд нь 2021.11.01-ний өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд сэндбоксын орчинд туршигдаж 2022.12.30-ны өдөр Сэндбоксын зөвлөлийн 04 дүгээр зөвлөмжөөр сэндбокс зохицуулалтын орчноос гаргасан.



## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд



Дорнод аймагт ажиллаж, зохицуулалтад хамаарагддаг банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаасны болон даатгалын компаниудад салбаруудын санхүүгийн үзүүлэлтүүдийн өнөөгийн байдлын талаар мэдээлэл өгөхийн хамт газар дээрх үзлэг, шалгалтыг хийж ажилласан байна. Үүний зэрэгцээ аймгийн төв буюу Хэрлэн сумын иргэд, олон нийтэд санхүүгийн салбар болон СЗХ-ны чиг үүргийн талаар мэдээлэл өгч, сонирхсон асуултад нь хариулж санал солилцлоо.

СЗХ-ны үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг олон нийтэд хүргэх, санхүүгийн зах зээлийн талаар сурталчлах хүрээнд нийт 221 мэдээ, 14 ярилцлага, нийтлэл, 15 видео мэдээг цахим хуудас, пэйж, твиттер, линкединд тус тус байршуулсны зэрэгцээ хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр түгээсэн.



Монголбанк, СЗХ, Зээлийн батлан даалтын сан, Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих сангаас хамтран БЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд нийслэлийн 9 дүүрэгт санхүүгийн боловсрол олгох сургалт зохион байгуулсан.



## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Санхүүгийн зах зээлд оролцогчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх хүрээнд

Зохицуулалттай санхүүгийн ба санхүүгийн бус бизнесийн салбаруудын тогтолцооны суурь асуудал болох үйл ажиллагааг хариуцан ажиллах ажилтан нь мэргэжлийн тусгайлсан болзол шаардлагыг хангуулах мэдлэг, мэдээлэлээр хангах зорилгоор СЗХ мэргэжлийн холбоодтой хамтарсан сургалтыг “Санхүүгийн зохицуулах хорооны сургалтын журам”-ын дагуу зохион байгуулж байна.



СЗХ мэргэжлийн холбоодтой хамтран эрх олгох сургалт, мөн бодлогын хүрээний асуудлаар мэдлэг, мэдээлэл түгээх зорилгоор сургалт, зөвлөгөө зохион байгуулж ажиллалаа.

Хүснэгт 3. Зохицуулалтын салбарт зохион байгуулсан сургалтууд

№	Зохицуулалтын салбарт зохион байгуулсан сургалтын төрөл	2022 оны ХБГ	
		Давтамж	Оролцогч
1	Эрх олгох сургалт	33	2162
2	Мэргэшүүлэх сургалт	12	255
3	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр	20	1020
4	Бусад сургалт	73	2375
Нийт		138	5812

“Сургалт зохион байгуулах гэрээ” байгуулсан 12 мэргэжлийн холбоодтой 14 төрлийн хөтөлбөрт хамаарах хамтарсан сургалтыг нийт 45 удаа зохион байгуулахад 2417 оролцогч хамрагдсанаас 1388 оролцогч тухайн зохицуулалттай салбарт ажиллах болзол шаардлагыг хангасан.

Компанийн засаглал, комплайнсын чиглэлээр Монголын хөрөнгийн биржийн 1, 2 дугаар ангилалд бүртгэлтэй 60 ХК, 34 ХОМК, даатгалын 17 компани, итгэлцлийн үйлчилгээ эрхэлж буй 52 ББСБ-ын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлагыг хамруулан шинэчлэн батлагдсан кодексийн танилцуулга, сургалтыг зохион байгуулж, хэлэлцүүлэг хийсэн.

Мөн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагаанд аудит хийх этгээдийг мэргэшүүлэх асуудлаар Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран онлайн, танхим хосолсон эрх олгох сургалтыг зохион байгуулж тус салбарт үүсэж буй бодит кэйс, типологийн талаарх холбогдох цуврал сургалтуудыг орж хамтран ажилласан.

Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Бичил санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд 2022.04.25–28-ны өдрүүдэд Дархан-Уул, Орхон аймагт сургалт зохион байгуулж аймгийн орон нутгийн телевизэд ярилцлага өгч, иргэдэд зориулсан гарын авлага тараасан.

## БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

СЗХ-нд давхардсан тоогоор 1620 хуулийн этгээдээс тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн хүсэлтийг цахимаар ирүүлснээс баримт бичгийн бүрдлийг хянаж шаардлага хангаагүй, бүрдэл дутуу 300 хүсэлтийг заавар, зөвлөмж өгч буцаан шаардлага хангасан 1320 хүсэлтийг хүлээн авч, холбогдох бүртгэл, зөвшөөрлийн чиглэлд шилжүүлсэн.

### Үнэт цаасны зах зээлийн чиглэлээр:

Нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг бүртгэх – 5;	ХБҮЦ бүртгэх—12;
Хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцааг бүртгэх— 2;	Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл олгох – 1;
Өрийг хувьцаагаар солих зорилгоор хаалттай хүрээнд гаргаж буй энгийн хувьцааг бүртгэх – 1;	Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх – 3;
Олон нийтэд нээлттэй арилжаалагдах өрийн хэрэгсэл бүртгэх –1;	Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх –2;
Хаалттай өрийн хэрэгсэл бүртгэх –1;	Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх – 5;
Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компанийн нэмж гаргах хувьцааг бүртгэх – ;	Үнэт цаасны зах зээлд брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох – 1;
Хувийн ХОС–г үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэх –8;	Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгох – 1;
Хамтын ХОС–тай холбоотой – 2;	Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах – 4;
ХОМК тусгай зөвшөөрөл олгох – 8;	Нэмж гаргасан хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасыг бүртгэх – 1;
Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгох –1;	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох –1.
Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл– 1;	
Оноосон нэр өөрчлөх –1	



Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг 368 хүнд олгосон.	
Даатгалын болон мэргэжлийн оролцогч компанийн салбар нээх 52 тусгай зөвшөөрлийг олгосон.	Даатгалын актуарчийн эрх болон бүртгэлийг 5 хуулийн этгээдэд олгосон.

### Даатгалын зах зээлийн чиглэлээр:

- ◆ Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгүүлэх–38;
- ◆ Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл–1;
- ◆ Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл–7;
- ◆ Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл –368
- ◆ Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл хүчингүй болгох–190;
- ◆ Эрх бүхий албан тушаалтан томилох зөвшөөрөл хүсэх–42;
- ◆ Даатгалын мэргэжлийн оролцогчийн хувьцаа эзэмшигчийн 17;
- ◆ Давхар даатгалын зуучлалын эрх хасуулах –1;
- ◆ Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүн өөрчлөх зөвшөөрөл–2;
- ◆ Оноосон нэр өөрчлөх—1;
- ◆ Хаягийн өөрчлөлт–16.



## БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зураг 5. Банк бус санхүүгийн байгууллагын салбарын тусгай зөвшөөрлийн мэдээлэл



### Банк бус санхүүгийн байгууллагын чиглэлээр:

Нийт 513 ББСБ зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлж байгаагаас зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг 479 ББСБ-ын 465 ББСБ буюу 97 хувь нь зээлийн мэдээллийн сантай гэрээ байгуулсан байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн 17, банк бус санхүүгийн үйл ажиллагааны нэмэлт тусгай зөвшөөрөл хүссэн 35, нэгдэх нийлэх 4, хаалттай өрийн бичиг гаргах 36, нийт 92 асуудлыг хянаж шийдвэрлэлээ.

ББСБ-уудын тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл хүссэн нийт 289 хүсэлтийг цахимаар хүлээн авч, бүртгэл хөтөлсөн нь цахим хүсэлтийн шийдвэрлэлт 99.3 хувийн биелэлттэй байна.

### Хадгаламж, зээлийн хоршооны чиглэлээр:

Тайлант хугацаанд 7 ХЗХ-нд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 62 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацаа сунгаж, 3 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хууль, журмын дагуу хүчингүй болгосон. Нэр бүхий 6 ХЗХ-оос салбар байгуулах, салбарын зөвшөөрөл хүчингүй болгох, оноосон нэр өөрчлөх болон санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн 7 хүсэлт ирүүлснийг хянаж холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангасан 4 ХЗХ-ны хүсэлтийг СЗХ-ны даргын тушаалаар тус тус шийдвэрлэсэн.

Хүснэгт 4. Банк бус санхүүгийн байгууллагуудын зөвшөөрөл, бүртгэлийн мэдээлэл

№	Зөвшөөрөл эрхийн нэр	Тоо
1	Шинэ тусгай зөвшөөрөл	17
2	Нэмэлт тусгай зөвшөөрөл олгох	35
3	Нэгдэх, нийлэх	4
4	Хаалттай өрийн бичиг	36
5	Оноосон нэр өөрчлөх	10
6	Салбар байгуулах	44
7	ХЗБ, ХНХ, ХНХБ	283
8	Хоёрдогч өглөг	3
9	Хаяг байршил өөрчлөлт	83
10	Гүйцэтгэх удирдлага өөрчлөлт	111
11	ТУЗ-ийн бүртгэл	45

ХЗХ-ны сонгуульд болон эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт бүртгүүлэх 109, хаягийн өөрчлөлт бүртгүүлэх 7, нийт 116 хүсэлт ирүүлснээс 99 хүсэлтийг хянан шийдвэрлэсэн. ХЗХ-ны нэгдсэн бүртгэлийн санд 142 ХЗХ-ны дэлгэрэнгүй мэдээллийг оруулж, 261 ХЗХ-ны өөрчлөлтийг тухай бүр шинэчилсэн.

## БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үл хөдлөх хөрөнгө зуучлал ба Үнэт металл, үнэт чулуу тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын чиглэлээр:



№	Зөвшөөрөл, бүртгэлийн нэр	Тоо
1	Тусгай зөвшөөрөл авсан ҮХЭХЗ-ын байгууллага	60
2	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон ҮХЭХЗ-ын байгууллага	3
3	ҮХЭХЗ-ын байгууллагын салбар нээх зөвшөөрөл	3
4	Тусгай зөвшөөрөл авсан ҮМҮЧЭТХЭХЭ хуулийн этгээд	7
5	Тусгай зөвшөөрөл авсан ҮМҮЧЭТХЭХЭ иргэн	29
6	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон ҮМҮЧЭТХЭХЭ хуулийн этгээд	1
7	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн ҮМҮЧЭТХЭХЭ хуулийн этгээд	1
8	Хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах	36
9	Оноосон нэр өөрчлөх	4
10	ҮМҮЧЭТХЭХЭ-ийн салбар нээх зөвшөөрөл	5
11	ҮМҮЧЭТХЭХЭ-ийн салбар нээн ажиллуулах зөвшөөрлийг хүчингүй болгох	1

### Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн чиглэлээр:

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу “Шилжилтийн үеийн зохицуулалт”-д хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө үйл ажиллагаа эрхэлж байсан 9 компанийг бүртгэж, нийт 15 компанийн үйл ажиллагааг зогсоож, улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн. “Шилжилтийн үеийн зохицуулалт” дууссанаас хойш нийт 4 компанид бүртгэл хийж одоогоор нийт 11 компани бүртгэлтэй байна.

Харин “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох журам”-д зааснаар “Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт”-тай хамтран 2022.10.31-ний өдрөөс эхлэн сургалт зохион байгуулж, шалгалтад тэнцэж, бүртгүүлэх хүсэлтээ өгсөн 2 аудитын компанийн холбогдох баримт материалыг шалгаж байна.



## ■ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Газар дээрх хяналт, шалгалтын хүрээнд:

Тайлант хугацаанд 371 зохицуулалттай этгээдэд газар дээрх хяналт шалгалт хийсэн бөгөөд шалгалтын тайлан дүгнэлтээр холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч илэрсэн зөрчил дутагдалд хугацаатай үүрэг даалгавар, УБАШ хүргүүлж биелэлтийг тооцсон.

"МИК ОССК" ХХК-ийн газар дээрх хяналт шалгалтын тайлантай холбоотой мэдээлэл, цаашид холбогдох хууль эрх зүйн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх 4 төрлийн саналыг бэлтгэн хүргүүлж, "Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн үйл ажиллагааны талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөлд тусгуулсан.

Эрсдэлд суурилсан аргачлалыг ашиглан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх ажлын хүрээнд салбар бүрийн эрсдэлд суурилсан 2022 онд хийж гүйцэтгэх хяналт шалгалтын төлөвлөгөөг батлуулан, газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажилласан.

СЗХ-ны эрх бүхий албан тушаалтан, улсын байцаагч нараас 2022 оны жилийн эцсийн байдлаар хялбаршуулсан журмаар шийдвэрлэх зөрчилд шийтгэл оногдуулах тухай шийтгэлийн хуудас 44, зөрчилд шийтгэл оногдуулах тухай шийтгэлийн хуудас 15, нийт 59 шийтгэлийн хуудас үйлдэж холбогдогч иргэн, хуулийн этгээдэд нийт 339.0 сая төгрөгийн торгууль оногдуулсан байна. Үүнээс хялбаршуулсан журмаар шийдвэрлэх зөрчилд шийтгэл оногдуулах тухай шийтгэлийн хуудсаар 194.0 сая төгрөгийн торгууль, зөрчилд шийтгэл оногдуулах тухай шийтгэлийн хуудсаар 145.0 сая

төгрөгийн торгуулийг тус тус оногдуулж Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлж ажиллалаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна" гэж заасан байдаг бөгөөд СЗХ-ны эрх бүхий албан тушаалтнуудаас шийтгэлийн хуудасны биелэлтээ хариуцан ажиллах хуулийн зохицуулалттай байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар үйлдэгдсэн нийт 59 шийтгэлийн хуудаснаас 45 шийтгэлийн хуудсаар оногдуулсан торгууль бүрэн төлөгдсөн, 7 шийтгэлийн хуудсаар оногдуулсан торгууль хэсэгчлэн төлөгдөж байна. Мөн 6 шийтгэлийн хуудсаар оногдуулсан торгууль төлөгдөх процесс ажиллагаа явагдаж байгаа бөгөөд 1 шийтгэлийн хуудсыг холбогдогч эс хүлээн зөвшөөрч шүүхийн байгууллагад нэхэмжлэл гаргасан байна.

Зураг 6. Газар дээрх хяналт, шалгалтын мэдээлэл, салбарын оролцогчдоор





## ■ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Зайнаас тавих хяналт шалгалтын хүрээнд:

Тайлант хугацаанд СЗХ–нд нийт давхардсан тоогоор сар, улирлын тайлан, мэдээ, асуулгыг үнэт цаас, даатгал, ББСБ, ХЗХ–ны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 16,437 этгээд ирүүлэхээс 12,495 этгээд буюу 76.0 хувь, ҮХХЗБ 842, ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээд 240, ҮМҮЧЭТХЭАЭ иргэн 1,903 буюу нийт 2,985 тайлан, мэдээ ирүүлснийг хянан баталгаажуулж, хариу хүргүүлж ажиллалаа.

Зайны хяналтын хүрээнд давхардсан тоогоор 4,552 зохицуулалттай этгээдэд тайлангийн хариу хүргүүлсэн бол 6,343 этгээдэд зохистой харьцаа, зохицуулалт үйлчилгээний хөлс, хууль журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар мэдэгдэл, улсын байцаагчийн албан шаардлагыг тус тус хүргүүлэн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллалаа.


Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын болон үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн тайлан, мэдээг хянах, мета датаг хэрхэн яаж өрөх, үр ашигтай хэрэгжүүлэх

талаарх гарын авлагыг боловсруулан хүргүүлж Монгол Улсын үл хөдлөх хөрөнгийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэх зорилгын дор Барилга хот байгуулалтын яамны хэрэгжүүлж буй “Орон сууцны мэдээллийн нэгдсэн портал” системд зохицуулалттай 2 салбарын тайлангийн мэдээний загварыг оруулсан.

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга, үнэлгээний хуудас”–ыг нийт зохицуулалттай салбарын мэдээлэх үүрэгтэй этгээдүүдээс 2022.01.07–2022.01.28 өдрүүдэд авч нэгтгэлийг гарган эрсдэлийг тодорхойлох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

ХЗХ–ны чиглэлээр 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 196 ХЗХ тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 190 ХЗХ нь бүх гишүүдийн хурлыг хуралдуулж холбогдох материалыг СЗХ–нд ирүүлснийг хянаж холбогдох зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа.

Зураг 7. Зайны хяналт, шалгалтын хүрээнд баталгаажуулсан тайлан, мэдээ /давхардсан тоогоор/



## ■ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

СЗХ нь 2022 онд нэхэмжлэгчээр 1, хариуцагчаар 17, нийтдээ 18 шүүхийн хэрэг маргаанд оролцож байгаа бөгөөд нийт хэрэг маргааны 12 нь буюу 66.6 хувийг Төрийн хяналт шалгалтын маргаан эзэлж байна. Харин зөрчлийн маргаан 2 буюу 11.1 хувийг эзэлж байгаа бол, тусгай зөвшөөрлийн маргаан, гэм хорын маргаан, цалин хөлс, олговор, хэм хэмжээний актын маргаан тус бүрдээ 1 буюу 5.6 хувийг тус тус эзэлж байна. Нийт 18 хэргээс 11 хэрэг нь бүрэн хянан шийдвэрлэгдэж дууссан бөгөөд эдгээр хэргүүдийг шүүхээс нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, хэргийг хэрэгсэхгүй болгох байдлаар тус тус шийдвэрлэсэн байна.

СЗХ нь 2022 онд өмнөх онд шийдвэрлэгдэж дуусаагүй 5 хэрэг, шинээр 13 нэхэмжлэл хүлээн авч, нийт 18 хэрэг, маргаанд нэхэмжлэгч, хариуцагчаар, оролцож байна. Үүнээс 11 хэрэг нь хянан шийдвэрлэгдэж дууссан бөгөөд үлдсэн 7 хэрэг хянан шийдвэрлэгдэж байна. Эрх зүйн ангиллын хүрээнд Захиргааны байгууллага, албан тушаалтан тэдгээрийн шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой хэрэг буюу Захиргааны хэрэг 15 байгаа бөгөөд нийт хэргийн 83.4 хувийг

эзэлж байгаа бол иргэний хэрэг 3 буюу нийт хэргийн 16.6 хувийг тус тус эзэлж байна.

2022 онд нийт хэрэг маргааны 38.9 хувь буюу 7 хэрэг нь Үнэт цаасны салбарт хамаарч байгаа бол 27.8 хувь буюу 5 хэрэг маргаан ББСБ-ын салбарт хамаарч байна. Харин даатгалын салбар 2 хэрэг буюу 11.1 хувь, үнэт металл эдлэл, үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбар мөн адил 2 хэрэг буюу 11.1 хувийг тус тус эзэлж байна. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбар болон бусад салбар /Төрийн алба, тендер/ тус бүр 1 хэрэг буюу тус бүртээ 5.6 хувийг эзэлж байна.



### Улсын байцаагчийн албан шаардлага

Газар дээрх хяналт шалгалтын тайлан, дүгнэлтээр холбогдох УБАШ болон хугацаатай үүрэг даалгаврын биелэлт 87 хувийн биелэлттэй, 6 хуулийн этгээд, 1 иргэнд зөрчлийн хэрэг нээж, 1 хуулийн этгээдийн гаргасан зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн. Үүнд: 3 хуулийн этгээд, 1 иргэнд 54 сая төгрөгийн торгуулийг хэсэгчлэн төлүүлэхээр, 7 сая төгрөгийн хохирол барагдуулах шийтгэл оногдуулснаас 3 хуулийн этгээд, 1 иргэнээс 11.2 сая төгрөгийн торгуулийг хуваарийн дагуу төвлөрүүлж, 7 сая төгрөгийн хохирлыг барагдуулсан. Нэр бүхий 1 хуулийн этгээдэд 2021 онд оногдуулсан 40 сая

төгрөгийн торгуулийг НДЗШШ-ээс хэвээр үлдээхээр магадалгаа гарсан.

Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн талаар ирүүлсэн 8 гомдол мэдээллийн дагуу хяналт шалгалтыг хийж 1 хуулийн этгээд, 7 иргэнд ЗТХ-ийн 11.30 дугаар зүйлийн 1.1 дэх заалтыг үндэслэн 68.0 сая төгрөгийн торгууль оногдуулсан бол нэр бүхий 2 ҮХХЗБ, 14 ҮМҮЧЭТХЭАЭ иргэний үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалтыг хийж 2 ҮХХЗБ-д зөрчлийн хэрэг нээж, хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан.

Зураг 8. Улсын байцаагчийн албан шаардлагын мэдээлэл




## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

СЗХ-ны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, санал, дүгнэлт гарган хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. 2022 онд цаасаар болон цахимаар нийт 599 өргөдөл, гомдол ирүүлснээс албан бичгээр буюу цаасаар 443, цахимаар 156 өргөдөл, гомдол хянан шийдвэрлэсэн.

Нийт өргөдөл, гомдлын 238 нь даатгал, 136 нь ББСБ, 128 нь үнэт цаас, 20 нь ХЗХ, 77 нь бусад чиглэлээр ирсэн байна.

Тайлант хугацаанд хувьцаа зөвшөөрөлгүй худалдсантай холбоотой гомдол гаргасан 2 иргэнд 51 сая төгрөг олгуулж, даатгалтай холбоотой 51 иргэн, хуулийн этгээдэд 541.8 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулахаар урьдчилан шийдвэрлэснээс, даатгагч 24 иргэн, хуулийн этгээдэд 174.4 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулсан.

Зураг 9. Өргөдөл, гомдол, тэдгээрийн шийдвэрлэлтийн мэдээлэл





## МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Эрсдэлийн удирдлага

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, инновацыг дэмжсэн, эрсдэлийг бууруулахуйц тогтолцоог бий болгох чиглэлээр СЗХ мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг виртуал хөрөнгийн салбарт үндэсний хэмжээнд үнэлэх, журам зааврыг боловсруулж батлуулах, хамтын ажиллагааг өргөжүүлж, иргэд, олон нийтийг анхааруулах шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

ФАТФ-ын Зөвлөмж 15 /Шинэ технологи/-ын үнэлгээг ахиулах чиглэлээр АНДМУТБ-т Дахин үнэлгээний тайлан, тодруулгыг тухай бүр хүргүүлж, техник зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр идэвхтэй ажиллаж Санхүүгийн хориг хэрэгжүүлэх байгууллага (ФАТФ)-ын АНДМУТБ-ээс Малайз Улсын нийслэл Куала Лампур хотод зохион байгуулсан “25 дахь удаагийн жилийн уулзалт”-д СЗХ-ны төлөөлөл оролцож зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнаснаар Монгол Улсын Зөвлөмж 15-ын үнэлгээг “хагас хэрэгжсэн” гэж 2021 онд үнэлснийг “дийлэнх нь хэрэгжсэн” болгож, 1 шатаар амжилттай ахиулсан. Зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулснаар Монгол Улс ФАТФ-ын нийт 40 техник зөвлөмжийн 39-ийн үнэлгээ “бүрэн хэрэгжсэн” болон “дийлэнх нь хэрэгжсэн” болж Монгол Улс ФАТФ-ын гишүүн бус орнуудаас зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулсан анхны улс боллоо.

Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийн хүрээнд Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулсан “Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 2021–2026 оны үндэсний хөтөлбөр”-ийг хамтран батлуулаад байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь нийт 8 зорилгын хүрээнд хийгдэх 197 ажлаас бүрдэх бөгөөд СЗХ-нд хамааралтай буюу үндсэн болон хамтран хэрэгжүүлэх 124 ажил үүрэг тусгагдаад байна.

МУТСТ чиглэлээр нэр бүхий 82 МҮЭ-дийн үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг гүйцэтгэж, холбогдох дүгнэлтийг гаргасан.

Үүнээс МУТС эрсдэлийн үнэлгээ, зайны хяналтад үндэслэн 108 МҮЭ-д УБАШ, давхардсан тоогоор 691 МҮЭ-д мэдэгдэл хүргүүлж, 25 МҮЭ-ийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг түдгэлзүүлсэн бол Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд заасан шилжилтийн үеийн зохицуулалт дуусах үед СЗХ-нд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлэх хүсэлт ирүүлээгүй нэр бүхий 15 этгээд болон СЗХ бүртгэхээс татгалзсан нэр бүхий 4 этгээдэд УБАШ хүргүүлж, үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авсан ба ВХҮҮ-ийн МУТС эрсдэлийн үнэлгээ, эрчимжүүлсэн зайны хяналтад үндэслэн нэр бүхий 39 ВХҮҮ-дэд давхардсан тоогоор 65 удаагийн мэдэгдэл хүргүүлсэн байна.

МУТСТ хяналт шалгалттай холбоотой судалгааг тогтмол шинэчлэн ажилласан ба нэмэлтээр ВХҮҮ, ВХ-тэй холбоотой цаг үеийн болон үнэ ханшийн судалгааг тасралтгүй хийсэн бөгөөд эдгээр судалгаа, СЗХ-ны зохицуулалттай салбарууд болон ВХҮҮ-ийн МУТС эрсдэлийн үнэлгээ, зайны хяналтад үндэслэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.



## МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


### Олон нийтэд мэдээлэл хүргэх, сургалт зохион байгуулах

СЗХ ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх зөвлөмжид дурдсанчлан сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг мэдээллийн бүхий л сувгийг ашиглан зохион байгуулж ажиллалаа. Үүний зэрэгцээ комплайнс буюу хууль тогтоомж болон бизнесийн ёс зүй, мэргэжлийн харилцааны хэм хэмжээний стандартын нийцлийг таниулах, мөрдүүлэх, цаашлаад санхүүгийн салбарыг ФАТФ-ын газар дээрх хяналт, шалгалтын үнэлгээнд бэлтгэх зорилгоор компанийн удирдлага, ажилтнуудад комплайнсын гэрчилгээ олгох хөтөлбөрт сургалтыг зохион байгуулж тэдэнд комплайнсын талаар бүрэн мэдээлэл, мэдлэг олгосноор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, зогсоох зэргээр комплайнсын эрсдэлийг удирдах чадварыг сайжруулах юм.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохицуулалттай салбарын мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, тэдгээрийг чадавхжуулах ажлын хүрээнд 2022 онд нийт 55 удаагийн сургалтаар 2,361 этгээд хамрагдаж, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай ойлголт, тогтолцоо, мэдээлэх үүрэгтэй этгээдийн үүрэг зэрэг сэдвээр мэдээлэл хүргүүлсэн.

Эрсдэлд суурилсан аргачлалыг хэрхэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, ФАТФ-ын зөвлөмж, стандартыг үр дүнтэй биелүүлэхэд тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэх, нэгдсэн ойлголттой болох, зохицуулалтын салбаруудад комплайнсын эрсдэлийн удирдлагыг нутагшуулах зорилгоор “Комплайнсын эрсдэлийг удирдахуй-2” хэлэлцүүлгийг зохион байгууллаа. 2021 онд СЗХ, “Санхүүгийн боловсролын зангилаа” ТББ-тай комплайнсын соёлыг төлөвшүүлэх чиглэлээр “Хамтран ажиллах санамж бичиг” байгуулсан бөгөөд тайлант хугацаанд санамж бичиг, хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийн хүрээнд комплайнсын ажилтны ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгууллаа.

МҮТСТ чиглэлээр хийгдсэн	Газар дээрх нийт хяналт шалгалтын тоо
Үнэт цаасны салбар	164
Даатгалын салбар	2
Банк бус санхүүгийн байгууллагын салбар	45
Хадгаламж, зээлийн хоршооны салбар	7
Үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбар	13
Үнэт металл, үнэт чулууны арилжааны үйлчилгээний салбар	12
<b>НИЙТ</b>	<b>243</b>





## ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

СЗХ зохицуулалттай салбарын хяналт, зохицуулалтын орчныг олон улсын стандартад нийцүүлж, хөл нийлүүлэн алхах зорилго болон зах зээлийн хөгжлийн чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажилладаг. Мөн улс орнуудтай харилцан туршлага солилцох зорилгоор санхүүгийн зохицуулагч байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



Олон улсын даатгалын зохицуулагч байгууллагуудын холбоо (IAIS)

Даатгалын компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэл, зах зээлийн чиг хандлага, цахим эрсдэл болон гуравдагч этгээдээр дамжуулан үйл ажиллагааныхаа нэг хэсгийг явуулахад гарах эрсдэл зэргийг судалж, эдгээр эрсдэлүүдийн даатгалын компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийг хэрхэн бууруулах боломжийн талаар судлах "Үйл ажиллагааны уян хатан байдлыг хангах ажлын хэсэг (ORTF)"-г ажиллаж байна.

Олон талт хамтын ажиллагааны санамж бичигт нэгдэн орох мэдүүлгийг хүргүүлсэнтэй холбоотойгоор IAIS-ийн үнэлгээний багаас ирүүлсэн 3 багц асуулгад хариу хүргүүлэв.

IAIS-аас Чили улсын Сантиаго хотноо зохион байгуулагдсан Олон улсын даатгалын зохицуулагчдын холбооны 29 дэх удаагийн жилийн тайлангийн хуралд СЗХ-ны төлөөлөл оролцов.



Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO)

2022 онд IOSCO-ын 47 дахь Жилийн тайлангийн хуралд оролцсон бол Ази-Номхон далайн бүсийн дэд хорооны "Хяналт шалгалтын хамтын ажиллагааны олон талт санамж бичиг"-г СЗХ нэгдэн орохтой холбогдуулан Санамж бичгийн хүрээнд ирүүлсэн асуумжуудад хариулж Санамж бичгийн үзэл баримтлалд СЗХ-ны мэдүүлгийг нийцүүлэн хүргүүлснээр санамж бичигт нэгдсэн.

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO)-ын Олон талт харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд гишүүн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, зохион байгуулж буй арга хэмжээнд идэвхтэй оролцох өргөтгөсөн олон талт хамтын ажиллагааны санамж бичигт нэгдэн орох СЗХ-ны мэдүүлэгтэй холбоотойгоор IOSCO Үнэлгээний хорооноос ирүүлсэн нэмэлт асуултуудын хариуг боловсруулж байна.



Олон улсын "Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн Дэлхийн бодлогын форум болон 2022 оны 5 дугаар сард зохион байгуулагдсан ажлын хэсгийн 7 уулзалтад СЗХ-ны холбогдох гишүүд оролцож, холбогдох зөвлөмж, гарын авлага бүтээхэд хамтран ажиллав.

"Зүүн Европ, Төв Азийн бүсийн санаачилга"-ын даргаар 2 дахь жилдээ ажиллав.



Азийн орнуудын хүртээмжтэй даатгалын талаарх мэдлэг

Уур амьсгалын эрсдэлээс хамгаалах хэрэгсэлд даатгал болон үүнтэй холбоотой дата мэдээлэл нь хэрхэн нөлөөлөх талаарх сургалтад оролцож, дата мэдээллийн үнэн зөв байдлын ач холбогдол болон даатгалын салбар нь эдгээр дата мэдээллийн тусламжтайгаар хэрхэн даатгалын хураамжийг үнэн зөв бодитойгоор тогтоож болох талаар хэлэлцлээ.





## ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА



БНСУ-ын Санхүүгийн үйлчилгээний хороо (FSC) болон Санхүүгийн хяналт шалгалтын байгууллага (FSS)

Зохицуулагч байгууллагууд МХБ-д бүртгэлтэй компаниудыг Солонгосын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх, хадгаламжийн бичиг гаргах боломж, эрх зүйн орчныг сайжруулах тухай болон хоёр орны мэргэжилтнүүдийг сургах, мэргэшүүлэх хүрээнд хамтран ажиллах цаашид “Санхүүгийн хянан шалгагчдын түншлэлийн хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэхийн зэрэгцээ шинээр зохицуулалтад ороод буй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэл, зохицуулалтын чиглэлд туршлага солилцох талаар хамтран ажиллахаар тохиролцсон.

### Японы Санхүүгийн үйлчилгээний агентлаг (FSA)



Японы Санхүүгийн үйлчилгээний агентлагаас хэрэгжүүлдэг “Глопак хамтын ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд 2 үе шаттай цахим сургалт зохион байгуулагдсан.

### БНЭУ-ын Үнэт цаас, биржийн хороо болон Даатгалын зохицуулалт, хөгжлийн газар



Гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр БНЭУ-ын Үнэт цаас, биржийн хороотой санамж бичиг байгуулсан бол Даатгалын зохицуулалт, хөгжлийн газартай санамж бичиг байгуулах уулзалтууд хийгдэж байна.

### Азийн хөгжлийн банк (ADB)

“Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд Орхон, Дархан-Уул аймгуудад үйл ажиллагаа явуулдаг ХЗХ-дыг хамруулан “ХЗХ-ны эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

“Төрийн нөөцийн удирдлага, хувийн хэвшлийн хөгжил, санхүүгийн салбарын гүйцэтгэлийг бэхжүүлэх” 2022–2025 оны хугацаанд хэрэгжих төсөлд санамж бичиг байгуулаад байна.

Финтекийн хууль эрх зүй, зохицуулалтын орчныг хөгжүүлэх төслийн баримт бичгийн санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан.

### Европын сэргээн босголт хөгжлийн банк (EBRD)



Үндсэн зургаан бүлэг, 25 дэд арга хэмжээ бүхий “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”-ийг боловсруулан батлуулсан.



### Японы Хамтын ажиллагааны агентлаг (JICA)

Төслийг амжилттай хэрэгжүүлж дуусган, эцсийн тайланг хүргүүлсэн бөгөөд төслийн дараагийн үе шатыг эхлүүлэхээр JICA-д санал хүргүүлж холбоотой нэмэлт асуултуудад хариулт боловсруулан хүргүүлсэн. Төслийн талаар санал солилцох цахим уулзалтуудыг зохион байгуулсан.



### Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй “Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”

Даатгалын багц хууль, Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагааг зохицуулах тухай хууль, Үнэт эдлэл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

“Санхүүгийн дүн шинжилгээ, эрсдэлийн удирдлага-II”-сургалт, “Нягтлан бодох бүртгэлийн актуудыг олон улсын стандартад нийцүүлэх сургалт”-ыг тус тус зохион байгуулсан.

Британийн Даатгалын Итгэмжлэгдсэн Институт (CII)-ын цахим сургалтад оролцлоо.



## ■ СУДАЛГАА, ТОЙМ

СЗХ нь санхүүгийн салбарын бодлого, зохицуулалт, хяналтын талаар шийдвэр гаргахдаа судалгаа, шинжилгээг үндэслэсэн урт хугацааны хөгжлийн гарцаа тодорхойлдог. 2022 онд:

- Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны зарчим, стандарт
- Сэндбокс зохицуулалтын журмын олон улсын харьцуулсан судалгаа
- Даатгалын компанийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга замууд, олон улсын туршлага гэх мэт 8 судалгааны ажлыг эмхэтгэн Судалгааны товхимол N3-ыг гаргасан.



САР БҮР

"ИРГЭН ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ" цуврал зурагт хуудас



УЛИРАЛ БҮР

СТАТИСТИК БЮЛЛЕТЕНЬ



УЛИРАЛ БҮР

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



САР БҮР

"ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ" сэтгүүл



САР БҮР

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН САРЫН ТОЙМ



7 ХОНОГ БҮР

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ

Салбарын тойм, сэтгүүл, тоон мэдээлэл, судалгааны ажлыг СЗХ-ны цахим хуудас ([www.frc.mn](http://www.frc.mn)), цахим шуудан ([rsa@frc.mn](mailto:rsa@frc.mn)) болон 51-261106 утсаар холбогдон авах боломжтой.



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

СЗХ-ны 2022 оны 145 дугаар тогтоолоор "Компанийн засаглалын кодекс" шинэчлэн батлагдав.

Шинэчлэгдсэн кодекс бусад орны сайн жишиг болон өөрийн орны онцлогт тохируулан компанийн засаглалын гол субъект болох төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн бүтэц, үйл ажиллагааны зарчмыг илүү тодорхой, нарийвчлан зохицуулсан юм. Тухайлбал, ТУЗ нь өөрөө кодексийн хэрэгжилтийг хариуцах, хяналт тавихаар үүрэгжүүлсэн бол нээлттэй хувьцаат компаниас гадна даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд кодексийг үйл ажиллагаандаа мөрдөхийг үүрэг болгосноор хамрах хүрээ нь тэлсэн.

Түүнчлэн ТУЗ-ийн хараат бус гишүүний чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг сайжруулах, зөрчлийг мэдээлэх, комплайнсын хяналтын тогтолцоо болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахдаа зайны технологийг нэвтрүүлэхийг үүрэг болголоо.

Үүний зэрэгцээ ТУЗ-ийн дарга, гишүүдийн олонх нь хараат бус байх, ТУЗ-ийн зүгээс гадаад болон жижиг хувьцаа эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгой анхаарах зөвлөмжүүд туссан. Мөн компаниудад кодексийн зарчмуудыг хэрэгжүүлэхэд тус дөхөм болох зорилгоор уг кодексийн хавсралтаар "Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн үлгэрчилсэн загвар"-ыг боловсруулан баталсан ба компанийн ТУЗ нь кодексийн хэрэгжилтийг тодорхой хугацаанд арилжаа эрхлэх байгууллагад тайлагнахаас гадна жилийн үйл ажиллагааны тайлан, цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлэх үүрэг өгсөн.

Хэрэв кодексийн хэрэгжилт хангалтгүй гэж үнэлэгдвэл тухайн үнэт цаасны бүртгэлийн ангилал буурах нөхцөл бүрдэх ба хөрөнгө оруулагчид санхүүгийн тоон үзүүлэлтийн харьцаанаас гадна компанийн засаглал талаас нь үнэлж, шийдвэрээ гаргах чанарын үзүүлэлттэй болох юм.





## МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ



“Зөвшөөрлийн цахим систем”-ийн хүсэлтийг цахимжуулах, нэгдсэн цахим системд суурь мэдээллийг нэгтгэж, систем жигд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар авахын зэрэгцээ эрх бүхий албан тушаалтан, хаяг байршил, агентын өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийг цахимжуулж, “Цахим албан тоот-ыг үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн.




Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх, бэлэн байдлын зэргийг тогтоож, бэлтгэлийг хангах хүрээнд:

1. Албан ёсны эрхтэй антивирус лиценз;
2. Албан ёсны эрхтэй галт хана лиценз;
3. Сервер компьютерын 2019 оны албан ёсны 6 лиценз;
4. Microsoft 365 системийг албан ёсны лиценз;

Дотоод үйл ажиллагаанд цаасны хэрэглээг бууруулж, зарим процессыг автоматжуулах чиглэлээр Microsoft 365 системд дараах системүүдийг гүйцэтгэж, нэвтрүүлсэн. Үүнд:

- ◆ Мэдээллийн технологийн дуудлагын бүртгэлийн программ;
- ◆ Хурлын ерөөний цаг бүртгэлийн программ;
- ◆ Цахим болон танхимын сургалтын мэдээллийн бүртгэлийн систем;
- ◆ Архивын баримт үзэх хүсэлт илгээх программ;
- ◆ Олон нийтийн үйл ажиллагааны мэдээллийн бүртгэлийн систем.




“Төрийн мэдээлэл солилцооны систем”-ээс нэмэлтээр дараах 5-н үйлчилгээг авахаар гэрээг байгуулан ажиллаж байна.

- ◆ Их, дээд сургууль, коллежид суралцаж байгаа тодорхойлолтын мэдээлэл дуудах;
- ◆ Тээврийн хэрэгслийн эзэмшигчийн түүхчилсэн мэдээлэл дамжуулах;
- ◆ Иргэний мэдээлэл тулгах ;
- ◆ Үл хөдлөх хөрөнгийн жагсаалт авах;
- ◆ Аж ахуйн нэгжийн тайлангийн мэдээлэл авах;




## ■ ТӨСӨВ, САНХҮҮ




2022 онд 7.5 тэрбум төгрөгийн төсөвтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж, үүний 59.6 хувийг улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэрээр, 40.4 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу зохицуулалт үйлчилгээний хураамжийн орлогын эх үүсвэрээр тус тус санхүүжүүлснээр СЗХ-ны үйл ажиллагааг жигд тогтмол тасралтгүй хэвийн явуулах санхүүгийн нөөцөөр хангаж ажилласан. Таилант хугацаанд зохицуулалт үйлчилгээний орлого 4.1 тэрбум төгрөг төвлөрч, биелэлт 99 хувьтай байна.

Зураг 10. Нийт зардал /хувиар/




**ОЛОЛТ, АМЖИЛТ**

2022



Банкны реформыг  
амжилттай  
хэрэгжүүлж,  
системийн нөлөө  
бүхийг 2 банк IPO  
гаргалаа



Төрийн өмчит  
компаниудын  
хувьчлалыг эхлүүлж  
“Монголын  
хөрөнгийн бирж”  
ХК хувьцаагаа олон  
ниитэд нэмж гаргав.




НОГООН  
ДААТГАЛЫН ЭРХ  
ЗҮЙН ОРЧИН  
БҮРДЛЭЭ



Виртуал  
хөрөнгийн үйлчилгээ  
үзүүлэгчийг хянаж,  
зохицуулж эхэллээ.



Баталгааны  
даатгалын эрхзүйн  
орчин бүрдлээ



Мөнгөн зээлийн  
үйл ажиллагааг  
зохицуулах тухай  
хууль батлагдлаа



